

ОУХМАСТЕР Б.АРИУН-ЭРДЭНИЙН НЭРЭМЖИТ ЖУДО БӨХИЙН ЗАЛУУЧУУДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Жудо бөхийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03
дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Булган суманд зохион

байгуулагдаж, хот, хөдөөгийн 24 багийн 250 жүдочид оролцож Эмэгтэй: багийн



дүнгээр I байр Эрдэнэбат дасгалжуулагчтай Улаанбаатар хотын Спортын дунд сургууль, II байр Цэвэлмаа дасгалжуулагчтай "Женко" клуб, III байр Шийрэв дасгалжуулагчтай Онцгой байдлын газар. Эрэгтэй: багийн дүнгээр I байр Энхбаяр дасгалжуулагчтай "Женко" клуб, II байр Шийрэв дасгалжуулагчтай Онцгой байдлын газар, III байр Балжинням дасгалжуулагчтай Дархан-Уул аймгийн баг тамирчид тус тус шалгарсан байна. **ОЛОН ХОТ БА БҮСИЙН ТЭМЦЭЭН**

“БУЛГАН ЦОМ-2019” ОЛИМПИЙН ТАЕКВОНДОГИЙН ОЛОН ХОТЫН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

“Булганы цом-2019” олимпийн таеквондогийн олон хотын аварга шалгаруулах 13 дахь удаагийн нээлттэй тэмцээн 2019 оны 01 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 22 клубын 250 гаруй тамирчид оролцлоо. Багийн дүнгээр: Өсвөр насны ангилалд I байр Орхон аймаг, II байр “онхе” клуб, III



байрыг Зүүнхараа багийн тамирчид мөн Бага насны ангилалд: I байр Орхон аймаг, II байр “ Нэгэн бүл” клуб, III байр “Эхлэл “клубын баг тамирчид эзэллээ. Шилдэг шүүгчээр Булган аймгийн шүүгч Б.Баянмөнх, Шилдэг дасгалжуулагчаар Орхон аймгийн дасгалжуулагч Б.Хос-хүлэг, Шилдэг эмэгтэй тамирчнаар “Хүч” спорт хорооны тамирчин Г.Отгончимэг, Шилдэг эрэгтэй тамирчнаар “Конхе” клубын тамирчин Ё.Пүрэвдаш нар тус тус шалгарлаа.

ӨСВӨР ҮЕИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ГАНДБОЛЫН ТЭМЦЭЭН “


Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн нэрэмжит 2019 оны Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах Гандболын тэмцээн 03 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд Булган аймгийн Спортын ордонд 2 өдөр амжилттай явагдлаа. Тус тэмцээнд 10 байгууллагын 28 багийн 320 гаруй тамирчид 2 насны ангилалаар оролцсоноос: Дунд насны ангилалд: I байр Дорноговь, II байр Булган аймаг, III байр Замын –Үүдийн баг тамирчид, Ахлах насны ангилалд: I байр Замын-Үүдийн баг тамирчид, II байр Дорноговь аймгийн баг тамирчид, III байр Булган аймгийн баг



тамирчид шалгарлаа. Тус тэмцээнээс Г.Бат-Эрдэнэ дасгалжуулагчтай Булган аймгийн эмэгтэй баг тамирчид 16-17 насны ангилалд алтан медаль, 14-15 насны ангилалд эрэгтэй, эмэгтэй баг тамирчид тус тус мөнгөн медаль хүртлээ.

“ ТӨВИЙН БҮСИЙН ЖУДО БӨХИЙН ТЭМЦЭЭН “

Төвийн бүсийн Жүдо бөхийн Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд спорт ордонд зохион байгуулагдаж, тус тэмцээнд Орхон, Төв, Сэлэнгэ, Дархан уул, Булган аймгуудын 381 тамирчид 47 жингээр оролцлоо.



“БУЛГАН АЙМГИЙН ПАУЭРЛИФТИНГИЙН ХОЛБООНЫ

НАСАНД ХҮРЭГЧДИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН

Волейболын спортын ОУХМастер Н.Содномдоржийн нэрэмжит 2019 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн Булган суманд 2019 оны 05 дугаар сарын 18-24 -ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд 18 багийн 160 гаруй тамирчид оролцсоноос Эрэгтэй: Тэргүүн байрыг "Эрчим" клуб II байрыг "Алтайн барс" III байрыг "Замчин" клуб, Эмэгтэй: Тэргүүн байранд Хилчин клуб, II байранд Булган аймгийн баг, III байранд Эрдэнэт хотын баг тамирчид шалгарлаа.

